



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/14/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжапрал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn
Аудитор: Н.Баттөгөлдөр
Утас: 261885 Цахим хаяг: battuguldurn@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ДАШДЭМБЭРЭЛ ТАНАА

2022.03.25 № 01/721
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,803,038,551.16	16,419,395,179.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,716,578,908.98	1,280,534,950.05
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,716,578,908.98	1,280,534,950.05
31210	Төгрөг	1,716,578,908.98	1,280,534,950.05
31213	Арилжааны банк дахь харилцах	1,716,578,908.98	1,280,534,950.05
33	АВЛАГА	86,459,642.18	15,138,860,229.59
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	80,368,942.18	73,230,229.59
33300	Татаас, санхүүжилтийн авлага	6,090,700.00	15,065,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,803,038,551.16	16,419,395,179.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,428,885,968.98	15,379,742,092.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,428,885,968.98	15,379,742,092.00
41300	Өглөг	1,428,885,968.98	15,379,742,092.00
41360	Бусад өглөг	1,428,885,968.98	15,379,742,092.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,428,885,968.98	15,379,742,092.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	374,152,582.18	1,039,653,087.64
51	Засгийн газрын хувь оролцоо	374,152,582.18	1,039,653,087.64
51200	Хуримтлагдсан үр дүн	374,152,582.18	1,039,653,087.64
51210	Өмнөх үеийн үр дүн	1,908,443,552.74	995,595,342.70
51220	Тайлант үеийн үр дүн	-1,534,290,970.56	44,057,744.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,803,038,551.16	16,419,395,179.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,609,101,383,458.59	2,990,228,337,708.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,753,442,058.59	120,867,288,315.97
120	Нийтлэг татварын бус орлого	49,753,442,058.59	120,867,288,315.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,753,442,058.59	120,867,288,315.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	330,266,058.59	1,931,832,308.97
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	49,423,176,000.00	118,935,456,007.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,559,347,941,400.00	2,869,361,049,393.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,559,347,941,400.00	2,869,361,049,393.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,559,347,941,400.00	2,869,361,049,393.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,610,635,674,429.15	2,990,184,279,964.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,610,635,674,429.15	2,990,184,279,964.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,470,942,666.23	1,416,177,362.29
2107	Томилолт, зочны зардал	16,797,910.00	16,759,810.00
210702	Дотоод албан томилолт	16,797,910.00	16,759,810.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,431,617,156.23	1,359,356,043.29

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,115,217,080.83	1,127,279,164.44
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	172,329,681.00	74,546,778.85
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	144,070,394.40	157,530,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,527,600.00	40,061,509.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,527,600.00	40,061,509.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,609,164,731,762.92	2,988,768,102,601.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,582,265,919,404.58	2,984,427,565,293.70
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,582,265,919,404.58	1,972,970,065,293.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,011,457,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,898,812,358.34	4,340,537,308.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,350,254,806.07	4,265,275,221.52
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	1,548,557,552.27	75,262,086.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,534,290,970.56	44,057,744.94
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,534,290,970.56	44,057,744.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,275,323,380.89	1,275,323,380.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	633,120,171.85	633,120,171.85
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,908,443,552.74	1,908,443,552.74
9	Тайлант үеийн үр дүн	-1,534,290,970.56	-1,534,290,970.56
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,152,582.18	374,152,582.18
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	374,152,582.18	374,152,582.18
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	621,442,760.52	621,442,760.52
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	995,595,342.70	995,595,342.70
19	Тайлант үеийн үр дүн	44,057,744.94	44,057,744.94
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,039,653,087.64	1,039,653,087.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,609,101,383,458.59	2,990,228,337,708.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,753,442,058.59	120,867,288,315.97
120	Нийтлэг татварын бус орлого	49,753,442,058.59	120,867,288,315.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,753,442,058.59	120,867,288,315.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	330,266,058.59	1,931,832,308.97
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	49,423,176,000.00	118,935,456,007.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,559,347,941,400.00	2,869,361,049,393.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,559,347,941,400.00	2,869,361,049,393.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,559,347,941,400.00	2,869,361,049,393.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,610,685,935,490.17	2,990,664,381,667.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,610,685,935,490.17	2,990,664,381,667.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,413,172,947.25	1,462,889,133.75
2107	Томилолт, зочны зардал	16,797,910.00	16,759,810.00
210702	Дотоод албан томилолт	16,797,910.00	16,759,810.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,373,847,437.25	1,406,067,814.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,057,447,361.85	1,173,990,935.90
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	172,329,681.00	74,546,778.85
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	144,070,394.40	157,530,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,527,600.00	40,061,509.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,527,600.00	40,061,509.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,609,272,762,542.92	2,989,201,492,534.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,582,367,859,484.58	2,969,795,325,226.11
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,582,367,859,484.58	1,971,896,375,226.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	997,898,950,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,904,903,058.34	19,406,167,308.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,356,345,506.07	19,330,905,221.52
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	1,548,557,552.27	75,262,086.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-1,584,552,031.58	-436,043,958.93
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,584,552,031.58	-436,043,958.93
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,301,130,940.56	1,716,578,908.98
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,716,578,908.98	1,280,534,950.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,988,344,885,400.00	2,851,090,480,439.38	2,851,090,480,439.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,988,344,885,400.00	2,851,090,480,439.38	2,851,090,480,439.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,070,310,200.00	1,462,889,133.75	1,462,889,133.75
2107	Томилолт, зочны зардал	41,678,200.00	16,759,810.00	16,759,810.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,940,235,000.00	1,406,067,814.75	1,406,067,814.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,397,000.00	40,061,509.00	40,061,509.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,986,274,575,200.00	2,849,627,591,305.63	2,849,627,591,305.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,986,274,575,200.00	2,849,627,591,305.63	2,849,627,591,305.63
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,988,344,885,400.00	2,865,719,786,480.45	2,865,719,786,480.45
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,988,344,885,400.00	2,865,095,774,171.48	2,865,095,774,171.48
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	624,012,308.97	624,012,308.97
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,716,578,908.98	1,716,578,908.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,280,534,950.05	1,280,534,950.05

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулах, төсвийн хэмнэлтийн талаар гаргасан ЗГ-ын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай хуваарилах, зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-наас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Н.Баттөгөлдөр нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/344 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зорилго нь Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэхэд оршино. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг олгох ажлыг зохион байгуулах;
- Төрд байгаа иргэний мэдээллийг иргэнээс шаардахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээ арга хэмжээнд хамруулах, түргэн шуурхай хүргэх, халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/ цахим системийг нэвтрүүлж үйлчилгээний менежментийг сайжруулах;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээтэй холбоотой иргэний өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудит мониторингийн газар нь батлагдсан удирдамжийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн Нийгмийн халамжийн сангийн 2021 оны эхний 3 улирлын санхүү аж ахуйн баримтанд дотоод хяналт шалгалт хийсэн байна. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээнд Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 16,106.6 сая төгрөгөөс 70 хувиар буюу 11,274.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,616.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, өглөг дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,280.5 сая төгрөг болж, өмнөх оноос 436 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	1,716,578.9	1,280,534.9	-436,044
Дүн	1,716,578.9	1,280,534.9	-436,044

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1,280.5 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,280.5 сая төгрөгөөс Төрийн банкинд байршиж буй 1,166.5 сая төгрөг, Хаан банкинд 114.0 сая төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 15,138.8 сая төгрөг болж, өмнөх оноос 15,052.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Татаас, санхүүжилтийн авлага	-	15,065,630.0	15,065,630.0
Байгууллагаас авах авлага			
Хувь хүмүүсээс авах авлага	86,459.6	73,230.2	-13,229.4
Дүн	86,459.6	15,238,860.2	

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь Монгол улсын иргэн бүрт олгох тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нийт 15 тэрбум төгрөгийг улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлагаар тусгаж Сангийн яамтай тооцоо нийлж ажилласнаас шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд насжилттай 64.2 сая төгрөгийн дараах авлага байна. Тухайлбал:

- Чингэлтэй дүүргийн ХХҮГазрын 53.1 сая төгрөгийн авлага
- Баянзүрх дүүргийн ХХҮГазрын 11.0 сая төгрөгийн авлага

3.5.3 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 15,379.7 сая төгрөг болж, өмнөх оноос 13,950.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг			
Байгууллагад төлөх өглөг			
Хувь хүмүүст төлөх өглөг	1,428,885.9	15,379,742.1	13,950,856.2
Дүн	1,428,885.9	15,379,742.1	13,950,856.2

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 13,558.5 сая төгрөгийн Монгол улсын иргэн бүрт олгох тэтгэмжийн өглөг, 1,506.8 сая төгрөгийн Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн өглөг, 314.4 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг байна.

3.5.4 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,039.6 сая төгрөг болж, өмнөх оноос 665.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал			
Хуримтлагдсан үр дүн			
Өмнөх үеийн үр дүн			
Хуримтлагдсан үр дүн	374,152.6	1,039,653.1	665,500.6
Дүн	374,152.6	1,039,653.1	665,500.6

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 665.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,988,344.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,357,444.8 сая төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 1,630,900 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 2,988,344.8 сая төгрөгөөр тодотгосон байна.

Энэ нь УИХ-аас баталсан коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд цар тахлын үед хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 0-18 насны хүүхдэд сар бүр 100.0 мянган төгрөг олгохоор, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж байгаатай холбогдуулан иргэдийг вакцинжуулах, тэдний орлого, дархлааг дэмжих зорилгоор Монгол улсын иргэн бүрт 300.0 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэгийг нэг удаа олгох шийдвэр гарсантай тус тус холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,988,344.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 118.9 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 2,869,361.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,865,077.7 сая төгрөг буюу 99 хувьтай байна.

Зарцуулагдаагүй үлдэгдэл 4,340.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 17 арга хэмжээнд 2,988,344.5 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 95.4 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орсон өөрчлөлт байхгүй бөгөөд аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 148 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь байршуулсан 147, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6. Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны батлагдсан төсөвт тусгасан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлаас эрдэм шинжилгээ, судалгааны ажил /Өрхийн судалгаа/-ын санхүүжилтийг харьяа 31 санд хуваарилахдаа үндэслэл болгосон шалгуур нь тодорхойгүй байна. Энэ Төсвийн тухай хуулийн 22.6.4. "Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах", 22.6.6. "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах"; заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 18,304.9 сая төгрөгийн 10 зөрчил илрүүлснээс 18,261.4 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 43.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг өгсөн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 180.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Өмнөх оны зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	-	1	-			
Зөвлөмж	1	180.0	1	180.0			
Нийт дүн		180.0		180.0			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар батлагдсан төсөвт тусгасан өрхийн судалгааны санхүүжилтийг хуваарилах нэгдсэн итгэлцүүр гаргах талаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,336.2 сая төгрөгийн 41 алдаа, зөрчил илэрснээс, 15,346.2 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 1.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 18,718.8 сая төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 257.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 16 зөвлөмж, 11.6 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад хүргүүлэх саналыг тус тус хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 685.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 11,274.4 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 31 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 28 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 27, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 16,031.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15,346.2 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 1.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 457.4 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 214.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 12 зөвлөмж, 11.6 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад хүргүүлэх саналыг тус тус хүргүүлсэн байна.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал:

Налайх дүүргийн Халамжийн сангийн Төрийн банкин дахь 312500529811 тоот харилцах дансны 4,727.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэж тайлагнаагүй, үүнээс 1,415.0 мянган төгрөгийг тус сангийн нягтлан бодогч хувийн дансандаа шилжүүлсэн, өмнөх онуудад байгууллагын дотоод хяналт шалгалтаар илэрсэн 10,199.2 мянган төгрөгийн төлбөрийг аудитын зөвлөмжийн дагуу авлагаар бүртгэхдээ харилцах данснаас зарлагын гүйлгээ гараагүй байхад Төрийн банкин дахь 31200640253 харилцах дансны кредитээс буруу бичилт хийсэн зэрэг нийт 11,614.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 “Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол улсын ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ...” заалтын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг Монгол улсын ерөнхий аудиторт хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

4.2.1.1 Нийгмийн халамжийн сангаас 2021 оны жилийн эцэст 20 хөтөлбөрөөс нийтдээ 19.3 тэрбум төгрөгийн төсөв хэмнэсэн ба уг эх үүсвэрээс 15.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс буцааж авахаар тооцож улсын төсвөөс авах авлага, хувь хүмүүст өгөх өглөгөөр тус тус тооцож авлага болон өр төлбөр үүсгэсэн байна. Сангийн яамтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ улсын төсвөөс авах авлага болон хувь хүмүүст өгөх өр төлбөрийн 15.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр байхгүйн улмаас дээрх хөтөлбөрүүдийн хэмнэгдсэн эх үүсвэрээс хүүхдийн мөнгөн тэтгэмж болон Монгол улсын иргэн бүрт олгох тэтгэмжийн эх үүсвэрийг бүрдүүлж авлага болон өр төлбөрөөр бүртгэсэн байна. Үүнийг үр дүнгийн тайланд төвлөрүүлсэн нийт санхүүжилт 19.3 тэрбум төгрөг гэж бичсэнийг тайлант оны зардлаар салгаж бичиж аудитын явцад залруулга хийсэн.

4.2.2 Албан шаардлага

Аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид дараах 5 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

4.2.2.1 Нийгмийн халамжийн тараах материалын худалдан авалтыг нээлттэй тендер зохион байгуулж, 149,039.1 мянган төгрөгийн гэрээ байгуулсан ба гэрээг дүгнэн, төлбөрийг бүрэн шилжүүлж, бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн боловч барааг бүрэн хүлээж аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.2.2.2 2022 оны 12 сард зохион байгуулсан сургалтын албан томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл, нотлох баримт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6. Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2.2.3 ХХҮЕГазар нь сургалт явуулах танхим бүхий 150 хүний багтаамжтай хурлын заалтай боловч сургалт семинар зохион байгуулахад түрээсийн байрны төлбөрт хөрөнгө зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6. Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2.2.4 Шилэн дансны цахим хуудсанд 147 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь байршуулсан 146, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна. Шилэн дансны тухай хууль 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2.2.5 Нийгмийн халамжийн сангийн 2021 оны батлагдсан төсөвт тусгасан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлаас эрдэм шинжилгээ, судалгааны ажил /Өрхийн судалгаа/-ын санхүүжилтийг харьяа 31 санд хуваарилахдаа үндэслэл болгосон шалгуур нь тодорхойгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 22.6.4."Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах", 22.6.6."Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах"; заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.2.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.

1.1 Илрүүлэлт:

1.2 Тайлант хугацаанд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхэд цахим и-баримтыг бүрдүүлээгүй байна.

1.3 Өгсөн зөвлөмж:

1.4 НӨАТ-ын тухай хуулийн 17.3.1.албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ; 17.5.Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Архангай ХХҮГазар	АРА-2022/219/-НА-СТА-ТШЗ	1	1					0	-	0		0		0		0			-
2	Баян-Өлгий ХХҮГазар		1	1					0	-										
3	Баянхонгор ХХҮГазар	БНА-2022/1/-НА-СТА-ЗГТС	1	1					0	-										
4	Булган ХХҮГазар	БУА-2022/140/-НА-СТА-ТШЗ	1	1					0	-										
5	Говь-Алтай ХХҮГазар	ГАА-2022/19/-НА-СТА-ОНТС	1	1					1	42,500.00					1	42,500.00				
6	Дорноговь ХХҮГазар	ДГА-2022/166/-НА-СТА-тшз	1	1					1	3,825.50	1	3,825.50								
7	Дорнод ХХҮГазар	ДОА-2022/170/-НА-СТА-тшз	1	1					0	-										
8	Дундговь ХХҮГазар	түүвэрт						1	0	-										
9	Завхан ХХҮГазар	ЗАА-2022/59/-СТА-тшз	1	1					0	-										
10	Өвөрхангай ХХҮГазар	ӨВА-2022/119/-НА-СТА-тшз	1	1					0	-										
11	Өмнөговь ХХҮГазар	ӨМА-2022/115/-НА-СТА-тшз	1	1					1	-	1									

**Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

12	Сүхбаатар ХХҮГазар	СБА-2022/174/-НА-СТА-тшз	1	1					0	-										
13	Сэлэнгэ ХХҮГазар	СЭА-2022/262/-НА-СТА-тшз	1	1					3	-									3	-
14	Төв ХХҮГазар	түүвэрт						1	0	-										
15	Увс ХХҮГазар	УВА-2022/183/-НА-СТА-тшз	1	1					1	1,200.00			1	1200						
16	Ховд ХХҮГазар	ХОА-2022/38/-НА-СТА-тшз	1	1					2	3,260.00			1	570					1	2,690.00
17	Хөвсгөл ХХҮГазар	ХӨА-2022/250/-НА-СТА-тшз	1	1					0	-										
18	Хэнтий ХХҮГазар	ХЭА-2022/193/-НА-СТА-тшз	1	1					0	-										
19	Дархан уул ХХҮГазар	ДАА-2022/114/-НА-СТА-тшз	1	1					0	-										
20	Орхон ХХҮГазар	түүвэрт						1	0	-										
21	Говьсүмбэр ХХҮГазар	ГСА-2022/2/СТА-3ГТС	1	1					0	-										
22	ХУД ХХҮХэлтэс	ХАК-2022/676/НА-СТА-ТШЗ	1	1					4	287,544.00	2	276,563.50		1	10,910.00				1	70.50
23	Багануур дүүрэг ХХҮХэлтэс	ХАК-2022/299/НА-СТА-ТШЗ	1	1					1	-									1	
24	БЗД ХХҮХэлтэс	ХАК-2022/202/НА-СА-ТШЗ	1	1					2	80,332.30				1	69,266.00				1	11,066.30
25	Налайх дүүрэг ХХҮХэлтэс	ХАК-2022/399/НА-СТА-ТШЗ	1		1				4	100,449.40				1	88,115.20	2	11614.2	1		720.00
26	БГД ХХҮХэлтэс 80220266	ХАК-2022/301/НА-СТА-ТШЗ	1	1					1	-									1	
27	СБД ХХҮХэлтэс	ХАК-2022/298/НА-СТА-ТШЗ	1	1					3	2,302.70	1	186.00		1	1,930.70				1	186.00
28	Чингэлтэй ХХҮХэлтэс	ХАК-2022/790/НА-СТА-ТШЗ	1	1					1	53,184.80				1	53,184.80					
29	Багахангай дүүрэг ХХҮХэлтэс	ХАК-2022/84/НА-СТА-ТШЗ	1	1					0	-	0									
30	СХД ХХҮХэлтэс	ХАК-2022/303/НА-СТА-ТШЗ	1	1					1	33,919.40									1	33,919.40
31	ХХҮГазар төв сан	АХГ-2022/14/НА-СТА-3ГТС	1	1					5	15,422,775.80	1	15,065,630.00		3	191,450.10				1	165,695.70
			28	27	1	0	0	3	31	16,031,293.90	6	15,346,205.00	2	1,770.00	9	457,356.80	2	11,614.20	12	214,347.90

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Дорнод ХХҮГазар	ДОА-2022/170/НА-СТА-тшз	1	0					1	0				
2	Багануур дүүрэг ХХҮХэлтэс	ХАК-2022/299/НА-СТА-ТШЗ	1	-									1	
3	БЗД ХХҮХэлтэс	ХАК-2022/202/НА-СА-ТШЗ	1	2,186,000.00					1	2,186,000.00				
4	Налайх дүүрэг ХХҮХэлтэс	ХАК-2022/399/НА-СТА-ТШЗ	1	446,191.00					1	446,191.00				
5	БГД ХХҮХэлтэс 80220266	ХАК-2022/301/НА-СТА-ТШЗ	2	43,480.40									2	43,480.40
6	СБД ХХҮХэлтэс	ХАК-2022/298/НА-СТА-ТШЗ	1	-									1	
7	СХД ХХҮХэлтэс	ХАК-2022/303/НА-СТА-ТШЗ	1	15,089,345.00					1	15,089,345.00				
8	ХХҮГазар төв	АХГ-2022/14/НА-СТА-ЗГТС	2	539,891.00					2	539,891.00				
			10	18,304,907.40	-	-	-	-	6.00	18,261,427.00	-	-	4.00	43,480.40



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 465/160160459
АХГ-2022/14/НА-СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн халамжийн сангийн тараах материалын худалдан авалтыг нээлттэй тендер зохион байгуулж, 149,039,100.00 төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэрээний дагуу барааг бүрэн хүлээж аваагүй байхад гэрээг дүгнэн, төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 "Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ: ... 49.2.10 гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дутуу хүлээн авсан бараа материалыг нийлүүлэгч компаниас хүлээн авах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-420.Docx

0001081961



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 766 /А 0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/14/НА-СТА-ЗГТС
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1.2022 оны 12 дугаар сард зохион байгуулсан сургалтад орон нутгийн харьяа байгууллагын ажилтнууд оролцоход зарцуулсан 35,451,000.00 төгрөгийн албан томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл, нотлох баримт хангалтгүй;

2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь сургалт явуулах танхим бүхий 150 хүний багтаамжтай хурлын заалтай боловч 90 орчим албан хаагч оролцох сургалт, семинар зохион байгуулахад зориулж сургалтын танхим түрээслэн, түрээсийн байрны төлбөрт 6,960,000.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 "Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, төсвийн хэмнэлттэй ажиллах бодлого баримтлах, албан шаардлагын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.10-20\chig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-422.Docx

0001081965



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 764/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/14/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 147 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" зэрэг заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 755/А0160459
АХТ-2022/14/НА-СТА-3Г7С

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны батлагдсан төсөвт тусгасан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлаас эрдэм шинжилгээ, судалгааны ажил /Өрхийн судалгаа/-ын 539,891,000.00 төгрөгийн санхүүжилтийг харьяа 31 санд хуваарилахдаа үндэслэл болгосон шалгуур нь тодорхойгүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 22.6.4 "Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах", 22.6.6 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагад хуваарилах зардлын санхүүжилтийн итгэлцүүр, шалгуурыг тодорхой болгох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

[illegible]

[illegible]